

## Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, тулгамдсан асуудал

Ёндонсүрэнгийн Жаргалсайхан

Доктор (Ph.D), ахлах шинжээч, jargalsaikhan@iss.gov.mn

Монгол Улс, Улаанбаатар, Стратеги судалгааны хүрээлэн

### Хураангуй

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага бий болсон. Үүнтэй холбогдуулан 2016 онд тус гурван улсын төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтын үеэр “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд нийт 32 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Өнгөрсөн хугацаанд бүтээн байгуулалтын ажлууд удааширалтай хэрэгжсэнээс шалтгаалан Монголоор дамжин өнгөрөх худалдааны урсгал дорвитой нэмэгдэж чадсангүй. Ялангуяа төмөр замын тээврийн коридор байгуулахаар төлөвлөсөн төслүүдээс нэг ч төсөл хэрэгжиж чадаагүй нь хөрөнгө санхүүжилтээс гадна засаг төрийн үйл ажиллагааны тогтвортой байдал, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлага, зохион байгуулалт алдагдсантай тодорхой хэмжээнд холбоотой.


Энэхүү өгүүлэл нь Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал, хүндрэл бэрхиээлийг тодорхойлоход оршино.

**Түлхүүр үгс:** Бүс ба зам, дэд бүтэц, хамтын ажиллагаа, худалдааны харилцаа, төмөр зам, автотээвэр

### Нэг. Монгол-Орос-Хятадын гурван талын хамтын ажиллагаа ба эдийн засгийн коридорын санаачилга

Дэлхийн эдийн засгийн коридор нь улс орнуудыг холбосон, худалдаа, тээвэр, эрчим хүч, дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг нэгтгэн хөгжүүлэх зорилготой стратегийн бүсүүд юм. Эдгээр нь бүс нутгийн эдийн засгийн интеграцийг хурдасгаж, улс орнуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлдэг. Дэлхийн эдийн засгийн гол коридорууд нь Хятадын “Бүс ба Зам” (BRI), Хятад-Пакистаны эдийн засгийн коридор (СПЕС), Орос-Иран-Энэтхэгийг холбосон Хойд-Өмнөд тээврийн коридор (INSTC), Транс-Европын тээврийн коридор, Этиоп-Өмнөд Суданыг холбосон LAPSET коридор, Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа (Central Asia Regional Economic Cooperation) зэрэг болно.

Зураг 1. “Бүс ба Зам” санаачилга



Эдгээрээс хамгийн үр дүнтэй, амжилттай хэрэгжиж байгаа коридор бол 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн Хятадын “Бүс ба Зам” санаачилга юм. Анх Хятадын зүүн эргийн өндөр хөгжилд хүрч буй хотуудыг хөгжлөөр дутуу дотоодын баруун бүс нутгууд болон Төв Ази, Зүүн Өмнөд ба Өмнөд Азийн хөршүүдтэй холбох зорилготой байсан бол бүс нутгийн коридор гэсэн анхны ойлголтоос давж, Ази, Европ, Африк тивийг холбосон худалдаа, тээврийн сүлжээ болж хүрээгээ тэлсээр байна. “Бүс ба зам” санаачилгад нэгдэн оролцож буй 140 гаруй улс БНХАУ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, бүтээн байгуулалтын 3000 гаруй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Гэрээ хэлэлцээр болон санхүүгийн бус хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 2025 оны байдлаар 1.4 их наяд ам.долларт хүрчээ. Үүний үр дүнд улс орнуудтай гадаад худалдаа, эдийн засгийн харилцаагаа тэлж, үйлдвэрлэл, экспортоо нэмэгдүүлэн, аж үйлдвэрлэлийн бүхий л салбарт шаардлагатай түлш, эрчим хүч, түүхий эдийн нөөцөө олон эх үүсвэрээс хангах найдвартай сувгийг бий болгож байна. Ялангуяа КОВИД-19 цар тахлын хорио хязгаарлалтын улмаас дэлхийн бүх улс орнуудын эдийн засаг уналтад орж байхад Хятадын эдийн засаг өсөлттэй байсан нь “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд байгуулагдсан коридоруудын үйл ажиллагаа тасалдалгүй явж, тэтгэж байсантай холбоотой юм. Тус санаачилгын хүрээнд багтаж байгаа Замын-Үүд-Улаанбаатар-Сүхбаатарын дамжин өнгөрөх Транс Монголын коридор нь ТрансСибирийн коридортой холбогддог. (ҮАБЗ-ийн ССХ, 2024)

Манай хойд хөрш ОХУ нь ЗХУ-ын задралын дараа зах зээлийн харилцаанд шилжсэнээр эдийн засгийн гүнзгий хямралд орж байсан. Владимир Путин 2000 онд Ерөнхийлөгч болсноос хойш газрын тос, байгалийн хийн үнэ ханш өссөн

таатай нөхцөлийг ашиглаж, нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлж, үнэ ханшийг өсгөж чадсанаар эдийн засгийн байдал тогтворжиж, дэлхийн топ эдийн засаг бүхий 20 орны тоонд багтах болсон. Тус улсын эдийн засгийн гол тулгуур нь Армен, Беларусь, Казахстан, Киргизийг багтаасан Евроазийн эдийн засгийн холбоо юм. Тус холбоо нь эдийн засаг, худалдааны интеграцийг гүнзгийрүүлэх, гааль, зах зээл, хөдөлмөр, хөрөнгө оруулалтын урсгалыг либералчлах зорилготой нэгдмэл зах зээлийн системтэй. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Орос Украинтай зөрчилдөөнд орж, дайн тулаанд хүрсэн, үүний улмаас Барууны орнуудын зүгээс тавьсан бүх талын хориг хязгаарлалтад орсон болон КОВИД-19 цар тахал зэрэг бүхий л хүндрэл бэрхшээлийг даван туулахад Евроазийн эдийн засгийн холбоо чухал үүрэгтэй байсан.

Манай улс дэлхийн бараг бүх улс оронтой худалдаа, эдийн засгийн харилцаатай боловч далайд гарцгүйн улмаас шууд харилцах боломжгүй, хөрш орнуудын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх шаардлагатай учир бараа бүтээгдэхүүний өртөг зардал өндөр, хугацаа ихээр алддаг зэргээр олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул байдаг. Энэхүү сул талыг арилгах, дэлхийн зах зээлд нэгдэж, эдийн засгаа өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд “Транзит Монгол” үндэсний хөтөлбөрийг анх 2008 онд Засгийн газрын 183 дугаар тогтоолоор баталж, амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд дараагийн “Талын зам” хөтөлбөрийг 2017 онд 142 дугаар тогтоолоор батлуулсан байна.

Монгол Улс 2025 онд дэлхийн 177 улстай бараа бүтээгдэхүүний арилжаа хийж, худалдааны эргэлт 27,013.6 сая ам.долларт хүрсэн. Үүнээс экспорт 15,701.5, импорт 11,312.1 сая ам.долларт тус тус хүрч, худалдааны тэнцэл 4,389.4 сая ам.долларын ашигтай гарсан байна. Монголын экспортын гол бүтээгдэхүүн нүүрс, зэсийн баяжмал, цэвэршүүлсэн алт, төмрийн хүдэр, газрын тос, жонш, цайрын ба молибдений баяжмал зэрэг уул уурхайн түүхий эдийн борлуулалт нийт экспортын 90.2 хувийг бүрдүүлж, Хятадад нийлүүлсэн. Харин мал, амьтан, ургамлын гаралтай болон хүнсний бүтээгдэхүүн, арьс, ширэн, оёмол, нэхмэл эдлэл, гутал, хувцас болон аж үйлдвэрийн төрөл бүрийн барааны экспорт ердөө 5.3 хувийг эзлэх болсон. Түүнчлэн Оросоос авдаг уламжлалт бүтээгдэхүүн болох түлш шатахуун, бордоо, цахилгаан эрчим хүч, битум, төмөр хийц, эдлэл, техник хэрэгсэл болон хүнсний зүйлс Монголын нийт импортын дөрөвний нэгийг эзэлж байна. (ҮСХ, 2025)

Манайх дээрх улсуудаас 24 улстай нь ашигтай худалдаа хийсэн ба худалдааны нийт эргэлтэд Орос, Хятадын эзлэх хувь хэмжээ нийтдээ 80 хувь, үүнээс Хятад дангаараа 69 хувийг эзэлж байгаа нь хөрш орнуудын Монголын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тод харуулж байна.

**Хүснэгт 1. Монголоос Орос, Хятадтай хийсэн гадаад худалдаа, сая ам.доллар**

Улс	2005	2010	2020	2021	2022	2023	2024	2025	Хувь
<b>Монголоос гаргасан экспорт</b>									
Хятад	513.4	2,466.4	5,493.6	7,638.6	11,061.6	13,940.2	14,420.7	14,027.0	89.3
Орос	27.2	82.7	57.3	112.8	93.4	112.7	100.7	60.3	0.4
Бусад улс	523.3	359.4	2,025.4	1,489.7	1,383.6	1,730.5	1,262.0	1,614.2	10.3
<b>Нийт экспорт</b>	<b>1,063.9</b>	<b>2,908.5</b>	<b>7,576.3</b>	<b>9,241.1</b>	<b>12,538.6</b>	<b>15,186.9</b>	<b>15,783.4</b>	<b>15,701.5</b>	<b>100</b>
<b>Монгол руу орсон импорт</b>									
Хятад	303.2	976.2	1,910.2	2,520.0	3,072.2	3,773.3	4,672.4	4,605.0	40.7
Орос	417.9	1,046.7	1,399.9	1,955.2	2,611.5	2,386.3	2,824.8	2,771.7	24.5
Бусад улс	456.2	1,177.1	1,988.8	2,370.2	3,020.7	3,090.6	4,117.4	3,935.4	34.8
<b>Нийт импорт</b>	<b>1,177.3</b>	<b>3,200.0</b>	<b>5,298.9</b>	<b>6,845.4</b>	<b>8,704.4</b>	<b>9,250.2</b>	<b>11,614.6</b>	<b>11,312.1</b>	<b>100</b>

Гадаад худалдааны нийт тэнцэл сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд байнга ашигтай гарах болсон нь Монголын уул уурхайн түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт Хятад руу эрс нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин Оростой хийх худалдаа байнга алдагдалтай байгаа бөгөөд Монголын бараа бүтээгдэхүүн Оросын зах зээлд гарч чадахгүй байгаагийн улмаас сүүлийн жилүүдэд энэ зөрүү улам бүр нэмэгдэх болсон. (ГЕГ, 2025)

**Хүснэгт 2. Монголын Орос, Хятадтай хийсэн гадаад худалдааны эргэлт, сая ам.доллар**

Улс	2005	2010	2020	2021	2022	2023	2024	2025	Хувь
Хятад	816.7	3,442.7	7,403.9	10,158.6	14,133.8	17,713.5	19,093.1	18,632.1	69.0
Орос	445.1	1,129.4	1,457.2	2,068.0	2,704.8	2,499.0	2,925.5	2,832.0	10.5
<b>Нийт эргэлт</b>	<b>2,241.1</b>	<b>6,108.5</b>	<b>12,875.2</b>	<b>16,086.6</b>	<b>21,243.0</b>	<b>24,437.1</b>	<b>27,398.0</b>	<b>27,013.6</b>	<b>100</b>

**Хүснэгт 3. Монголын Орос, Хятадтай хийсэн гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллар**

Улс	2005	2010	2020	2021	2022	2023	2024	2025
Орос	210.2	1,490.2	3,583.4	5,118.5	7,989.3	10,166.9	9,748.2	9,422.2
Орос	-390.7	-963.9	-1,342.7	-1,842.4	-2,518.1	-2,273.6	-2,724.1	-2,711.4
<b>Нийт тэнцэл</b>	<b>-113.4</b>	<b>-291.5</b>	<b>2,277.4</b>	<b>2,395.7</b>	<b>3,834.2</b>	<b>5,936.6</b>	<b>4,168.7</b>	<b>4,389.4</b>

Монгол, Орос, Хятадын Төрийн тэргүүн нар анх Тажикистаны Душанбед 2014 онд уулзаж, Хятадын Торгоны зам (Бүс ба Зам)-ын эдийн засгийн бүсийн

хөгжлийн бүтээн байгуулалт, Оросын Евроазийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, Монголын “Талын зам” санаачилгыг уялдуулж, Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор (ЭЗК) байгуулахаар тохиролцсон бол Оросын Уфад 2015 онд болсон хоёр дахь уулзалтаар санамж бичиг байгуулсан. Үүний дагуу Талуудын холбогдох байгууллагууд ажилласны үр дүнд Узбекистаны Ташкент хотноо 2016 оны зургаадугаар сард болсон тус гурван улсын Төрийн тэргүүн нарын гурав дахь уулзалтын үеэр Монгол-Орос-Хятадын ЭЗК байгуулах хөтөлбөрийг баталсан юм.

ЭЗК-ын хөтөлбөрийн хүрээнд зам, тээврийн салбарын 13 (үүнд төмөр замын 8, автозам, автотээврийн 5), аж үйлдвэрийн 2, хил, гааль, хорио цээрийн салбарын 5, эрчим хүчний 1, байгаль орчны 3, шинжлэх ухаан, технологи, боловсролын 3, хүмүүнлэгийн 3, хөдөө аж ахуйн 1, эрүүл мэндийн салбарын 1, нийт 32 төслийг хэрэгжүүлэхээр болсон. ЭЗК байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын талаас ГХЯ хариуцан ажиллаж байгаад 2023 оны долоодугаар сараас ЭЗХЯ-д харьяалагдсан бол нөгөө талуудаас ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороо хамаарч байна. Эдгээр байгууллага нь хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, цаашдын арга хэмжээг тохиролцох зорилгоор жилд нэгээс багагүй удаа уулзалт зохион байгуулахаар тохирсон. (ЕТГ, 2016) Энэхүү хөтөлбөр нь 5 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд хэрэгжих хугацаа дуусгавар болсны дараа биелэлтийг хамтран дүгнэж, түүний үр дүнгээс хамаарч талууд харилцан тохиролцсоноор хэрэгжих хугацааг дахин 5 жилээр сунгаж болохоор заасан. Үүний дагуу гурван улсын Төрийн тэргүүн нар 2022, 2025 онд болсон зургаа болон долоодугаар уулзалтын үеэр хөтөлбөрийн хэрэгжих хугацааг сунгаад байна. (<https://president.mn>, 2022)

## **Зураг 2. Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын 2025 оны есдүгээр сард Бээжин хотноо хийсэн уулзалт**



Хөтөлбөрийг баглах болон хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төрийн тэргүүн нарын уулзалт ШХАБ-ын дээд хэмжээний арга хэмжээний үеэр Душанбе (2014.09.11), Уфа (2015.07.09), Ташкент (2016.06.23-24), Чиндао (2018.06.09), Бишкек (2019.06.14), Самарканд (2022.09.15), Бээжин (2025.09.02)-д болж, нийт долоо удаа зохион байгуулсан. Түүнчлэн 3 талын Ерөнхий сайд нарын уулзалт Исламабадад (2024.10), Гадаад хэргийн сайд нарын уулзалт Астана хотод (2024.07.03), Гадаад хэргийн дэд сайд нарын зөвлөлдөх уулзалт Улаанбаатар (2014.10.30), Бээжинд дөрвөн удаа (2015.03.23, 2016.06.08, 2018.05.28, 2025.05.29) болон цахимаар (2022.08.30) зохион байгуулсан. Харин Шинжээчдийн уулзалтыг гурван улсын холбогдох яамдын газрын даргын түвшинд Бээжин (2017.03.24), Москва (2017.08.29), Улаанбаатар (2018.12.10-11), Москва (2023.06.30) болон цахимаар (2018.05.30, 2021.11.12, 2025.08.18), нийт долоон удаа хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, дээд түвшний уулзалтын бэлтгэлийг хангахад голлон анхаарч ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан ажиллах эрх бүхий байгууллагуудын уулзалтыг сайдын түвшинд зохион байгуулж байгаагүй байна.

“Монголын худалдааг дэмжих” төсөл болон Монголын Хятад судлалын хөгжлийн хүрээлэн хамтран “Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийг урагшлуулах боломж” судалгааг 2020 онд хийсэн бөгөөд судалгаагаар 32 төслийн 18 нь хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа, 14 төсөл нь хэрэгжээгүй болон хоцрогдолтой, нийт хэрэгжилтийн дундаж үнэлгээ 56.2 хувь гэсэн дүгнэлт гарсан. (Монголын Хятад судлалын хөгжлийн хүрээлэн, 2020) Мөн БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос тус улсын Төмөр замын газраар ахлуулсан ажлын хэсэг байгуулж, ЭЗК-ын төмөр замын төв шугамыг шинэчлэх төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг хийсэн. Уг ажлын хүрээнд ЭЗК-ын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 32 төслийн хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар судалгаа хийж, хэрэгжиж дууссан болон хэрэгжиж буй, удаашралтай хэдий ч ахицтай, хэрэгжих боломжгүй болон зогссон гэдэг байдлаар гурван хэсэгт ангилж, төслийн жагсаалтыг шинэчлэх саналыг 2023 оны дөрөвдүгээр сард боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 252 дугаар тогтоолоор “Бүс ба Зам” санаачилга, “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Эдийн засаг, хөгжлийн яаманд хариуцуулж, хэрэгжилтийг эрчимжүүлж, төслийн жагсаалтыг шинэчлэх ажлыг шуурхай эхлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад даалгасан байна. Үүний дагуу Москва хотноо 2023 оны зургаадугаар сард болсон ЭЗК-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаарх ажлын хэсгийн VI хуралдаанаар хөтөлбөрийн төслийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах асуудлыг судлахаар болсон. Үүний дагуу талууд төслийн шинэчилсэн жагсаалтын төсөл дээр ажиллаж, санал солилцсоны үндсэн дээр нийт 33 төсөл, арга хэмжээг шинэчлэн тохирч, 2024 оны 11 дүгээр сард харилцан мэдэгдсэнээр албан ёсоор баталгаажуулсан. (ЭЗХЯ, 2026)

### **Хоёр. ЭЗК-ын хөтөлбөрийн шинэчилсэн 33 төслийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүн**

ЭЗК-ын хөтөлбөрийн өмнөх төслүүдээс есөн төслийг хассан бол, нэмж 10 төслийг шинээр оруулснаар шинэчилсэн жагсаалтад нийт 33 төсөл, арга хэмжээ багтсан. Үүнээс зам, тээврийн салбарын 11, худалдааг дэмжих 6, шинжлэх ухаан, техник, боловсролын 4, ногоон хөгжлийн 3, эрүүл мэндийн 2, эрчим хүч, аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн салбарын тус бүр 1, чухал ач холбогдол бүхий 4 төсөл багтаж байна. Стратеги судалгааны хүрээлэнгээс 2026 онд ЭЗК-ын хөтөлбөрийн 33 төслийн хэрэгжилтийн байдалд судалгаа, үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн. Судалгааны ажлын хүрээнд төсөл тус бүрээр, хариуцсан яам, агентлагийн удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзаж, Монгол болон Орос, Хятадын талаас төслүүдийн хэрэгжилтийн чиглэлээр хийсэн ажил, тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээл, цаашид хийх ажил, төслийн ЭЗК-т гүйцэтгэх үүрэг, ач холбогдол гэсэн үзүүлэлтүүдээр үнэлж үзжээ. Үнэлгээгээр бүрэн хэрэгжсэн төсөл байхгүй бол 70 хувийн хэрэгжилттэй 5, 50 хувийн хэрэгжилттэй 7, 30 хувийн хэрэгжилттэй 15, тодорхой ажил хийгээгүй 6 төсөл байгаа бөгөөд хэрэгжилт 34.8 хувийн дундаж үнэлгээтэй гарсан байна.

Ийнхүү хөтөлбөр батлагдсанаас хойш 10 гаруй жилийн хугацаа өнгөрсөн боловч гурван улсыг дамнасан төмөр замын долоон коридор байгуулах төслүүдээс нэг ч төсөлд бодитой ахиц дэвшил гарсангүй. Үүнтэй холбоотойгоор 2024 онд төслийн жагсаалтад төмөр замын чиглэлээр Хойд, Баруун коридор болон Москва-Улаанбаатар-Бээжингийн хурдны төмөр зам барих гурван төсөл хасагдаж, хоёр төсөл нэмэгдсэн байна.

Шинээр нэмэгдсэн Улаан-Үд-Наушки-Сүхбаатар-Сайншанд-Зүүнбаян-Ханги-Мандал- Бугат-Ордос-Ши Ан чиглэлд Ханги-Мандал боомтыг төмөр замаар холбох төсөл есдүгээрт эрэмбэлэгдэж байгаа боловч Ханги-Мандалын төмөр замын өртгөөнүүд холбогдсоноор экспорт, импортоос гадна дамжин өнгөрөх тээвэрт ашиглах, Хятадын зүүн эргийн далайн боомт руу хүрэх болон Казахстангаар дамжин, Ази-Европыг холбосон гол коридорт холбогдох, хамгийн ойрын үед бодитой хэрэгжих боломжтой төсөл болж байна.

Төслүүдийн эхэнд эрэмбэлэгдсэн Төмөр замын Төв коридорыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах боломжийг судлах ажлын хүрээнд гурван тал өөрсдийн хэсэгт хамаарах ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан боловч нэгтгэх, нэгдсэн санал дүгнэлт гаргах ажил хүлээгдэж байна. Төсөл бүрэн хэрэгжснээр тус коридорын тээх, нэвтрүүлэх чадварыг бараг гурав дахин нэмэгдүүлж, жилд 90 сая.тн-д хүргэх бөгөөд бүтээн байгуулалтын ажилд багагүй хугацаа орохоос гадна 2050 онд төслийн бүрэн хүчин чадалд хүрэх тооцоолол гарсан байна.

Мөн төмөр замын бусад төсөл эхний төслийн хэрэгжилт, үр дүн гарсны дараа үргэлжлэхээр хүлээгдэж байна. Эдгээр төсөлд Находка, Зарубинотой холбогдох

Чойбалсан-Сүмбэрийн төмөр зам болон Жинжоу боомттой холбогдох Чойбалсан-Бичигтийн төмөр зам хамаарч байна.

Азийн автозамын сүлжээний АН-4 коридорын Монголын талд хамаарах Ярантай-Улаанбайшинт хэсгийг 2022 онд, АН-3 коридорын Улаанбаатар-Дарханы 204 км автозамыг 4 эгнээ болгон 2023 онд шинэчилснээр Монголын талын дээрх коридоруудыг дамжин өнгөрөх тээвэрт ашиглах боломж бүрдсэн. Гэвч тус коридороор Монголын нутгаар дамжин өнгөрсөн гадаадын тээврийн хэрэгслийн тоо 2024 онд 999, 2025 онд 1262 байгаа бөгөөд бусад коридор, ялангуяа Казахстанаар дамжих урсгал 250.0-350.0 мянган тээврийн хэрэгсэл нэвтэрч байгаагаар харьцуулахад маш бага юм.

Зураг 3. Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридорын сүлжээ



Олон улсын автогэврийн харилцааны тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2023 онд шинэчлэн байгуулсан нь Монголын тээвэрчдэд Хятадын нутаг дэвсгэрээр дамжин Вьетнам зэрэг Зүүн Өмнөд Азийн орнууд болон Төв Азийн Казахстан, Киргиз, Тажикистан руу дамжин өнгөрөх тээвэр хийх эрх зүйн боломжийг нээсэн. Одоогоор Хятадын тээвэрчид АН-3, АН-4 чиглэлийн дагуу Монголын нутаг дэвсгэрээр дамжин Орос руу тээвэрлэлт хийж эхэлж байгаа бол Монголын тээвэрчид хараахан яваагүй байна. Монголын тээвэрчид Хятадын нутаг дэвсгэрээр дамжин тээвэрлэлт гүйцэтгэхэд жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн улсын дугаар, жолоочийн ажил, амралтын дэглэмийг хянах төхөөрөмжийг олон улсын шаардлагад нийцүүлэх, хариуцлагын даатгалын сүлжээнд хамрагдах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хилийн боомт, эрчим хүчний чиглэлээр дорвитой ажил хийгдээгүй бол хүрээлэн байгаа орчин, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа,

хүмүүнлэг, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарын төслүүдийн хэрэгжилт эдийн засгийн коридорын хөгжилд төдийлөн үр нөлөөтэй байж чадахгүй байна. Аж үйлдвэр, ногоон хөгжил, шинжлэх ухаан, техник, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарын төслүүдийн хэрэгжилт гол төлөв 50-70 хувийн хэрэгжилттэй байгаа боловч эдийн засгийн коридор, дэд бүтцийн бүтээн байгуулалттай төдийлөн шууд хамаарал багатай, салбарын хамтын ажиллагааны шугамаар явж байгаа ажлуудын гүйцэтгэлийг хамруулсан байдалтай байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын 5 дахь Ерөнхий сайд ажиллаж байгаа бөгөөд ихэнхдээ Засгийн газрууд хугацаанаасаа өмнө огцорч байсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих анхаарал, хяналт сулрахад хүргэжээ гэж үзэж болохоор байна. Ялангуяа төслүүдийг хариуцан ажиллаж байсан сайд, агентлаг, газрын дарга, мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүн ихээхэн өөрчлөгдсөнөөс шалтгаалан хөтөлбөрийн шинэчилсэн жагсаалтад багтсан төслүүдийн талаарх мэдээлэл, мэдлэг дутмаг байх байдал зарим яам, байгууллагад илэрч байна. Тэгвэл Орос, Хятадын талд үйл ажиллагааны бодлого, зохицуулалтын уламжлалаа хадгалж, удирдлага болон хэрэгжүүлэх түвшинд хүний нөөцийг тогтвортой ажиллуулж байх бөгөөд Оросын ЕАЭЗХ-ны хүрээнд болон Ази руу чиглэсэн эдийн засгийн коридор, Хятадын “Бүс ба Зам” санаачлагын бүхий л төслүүд амжилттай хэрэгжиж, үр ашгаа өгч, эдийн засгийн асар хурдацтай өсөлт хөгжлийг тэтгэж дэмжиж байна.

Монгол Улсын Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг УИХ-аас 2010 онд баталснаас хойш 16 жил болж байгаа боловч 5683.5 км төмөр замыг 3 үе шаттайгаар гүйцэтгэхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар Тавантолгой-Зүүнбаянгийн чиглэлийн 416 км төмөр зам 2023 онд, Тавантолгой-Гашуунсухайт (233.6 км), Зүүнбаян-Ханги (226.9 км) чиглэлийн төмөр замууд 2022 онд ашиглалтад орсноор 876.5 км төмөр замыг барьж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт 15.2 хувьтай байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг хувийн хэвшлийн “Энержи ресурс” ХХК барьж байсан бөгөөд 2-3 жилийн дотор барьж ашиглаж эхлэх боломжтой байсан тус төмөр замыг төрийн мэдэлд шилжүүлэн авснаар бүтээн байгуулалтын ажил 10 гаруй жил саатснаас гадна одоо ч Хятадын төмөр замтай холбогдож чадаагүй, улс хоорондын тээвэрт ашиглах боломжгүй байна. Тэгвэл “Болдтөмөр Ерөө Гол” ХХК Дулаанхаан-Ерөөгийн 98 км төмөр замыг хоёр жилийн хугацаанд барьж, 2012 онд ашиглалт оруулж байсан бол Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км төмөр замыг мөн адил хоёр жилийн хугацаанд барьж, 2023 ашиглалтад оруулаад байна. Ийнхүү төмөр замын бүтээн байгуулалтад төрийн оролцоо хэт өндөр байснаар өртөг зардал нэмэгдэж, хугацаа ихээр алдаж байгаа бол хувийн хэвшлийн санал санаачилга, хөрөнгө оруулалтаар хийсэн бүтээн байгуулалт бүр богино хугацаанд хэрэгжиж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж байна.

## Дүгнэлт

1. Монголын хувьд гурван улсын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр баталснаас хойш 10 гаруй жилийн хугацаа өнгөрөөд байгаа боловч анх тавьсан хөтөлбөрийн зорилтын хүрээнд нийгэмд бий болсон хүлээлтийн хэмжээнд үр дүн гарсангүй. Үүнд Орос-Украины дайн, КОВИД-19 цар тахал зэрэг олон улсад бий болсон хүндрэл бэрхшээлээс гадна манай дотоодын улс төрийн тогтворгүй байдал, үйл ажиллагааны залгамж чанар алдагдсан нь төслүүдийн хэрэгжилтийг сааруулсан гол хүчин зүйл болжээ.
2. Эхний ээлжинд Төмөр замын Төв коридорыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх төслийн ТЭЗҮ-ийн гурван талын саналуудыг нэгтгэж батлах асуудлыг яаралтай шийдвэрлэх нь хүлээгдэж буй бусад төслийг хөдөлгөх боломжийг бүрдүүлнэ. Төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд Монголын талыг ахалж буй Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын түвшинд онцгой анхаарал хандуулж, 2031 онд хөтөлбөрийн ээлжит хугацаа дуусахаас өмнө бодит үр дүнд хүрэх нарийвчилсан нэгдсэн төлөвлөгөө боловсруулан бүх яам, агентлагийн удирдлагыг уялдаа холбоотой ажиллуулах шаардлагатай байна.
3. Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын ахалдаг Засгийн газрын дэргэдэх Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны чиг үүргийг өргөжүүлж, дамжин өнгөрөх тээвэр болон ЭЗК-ын асуудлыг нэгтгэн хамруулсан “Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хороо” болгон өөрчлөн зохион байгуулах нь төслийн хэрэгжилтийг хангах, институцийн чадамжыг бэхжүүлэхэд ач холбогдолтой байх болно.
4. Төмөр замын бүтээн байгуулалтад хувийн хэвшлийн санал санаачлага, хөрөнгө оруулалтыг дэмжих, түлхүү оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлснээр төслүүдийг богино хугацаанд, үр ашигтай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.
5. Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төслүүдийн хэрэгжилтийг урагшлуулах, саатсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороотой өндөр түвшний нягт хамтын ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.
6. Эдийн засгийн коридорын төслүүдийн эдийн засгийн үндэслэл, судалгаа тооцоог нарийвчлан хийх, хэрэгжилтэд шинжлэх ухаан, техник технологийн талаас дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээний байгууллагуудын оролцоог хангах, энэ тал дээр Үндэсний хөгжлийн хүрээлэнг түшиглэж ажиллах нь зүйтэй байна.

### Эх сурвалжийн жагсаалт

- <https://president.mn>. (2022 оны 9 12). Монгол, Орос, Хятадын Төрийн тэргүүн нар уулзав: <https://president.mn/24745/-ээс> Гаргасан
- ГЕГ. (2025 оны 12). <https://gaali.mn/>. <https://gaali.mn/statistic/>: <https://gaali.mn/statistic/news/6960d376b9d444695304320c-ээс> Гаргасан
- ЕТГ. (2016). Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр. Ташкент. Монголын Хятад судлалын хөгжлийн хүрээлэн. (2020). “Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийг урагшлуулах боломж” судалгаа. Улаанбаатар.
- Намжим, Т. (2004). Монгол Улсын эдийн засаг 755-756 тал. Улаанбаатар.
- тогтоол, З.Г-ын. 1.-р. (2008 оны 05 14). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=5400.-ээс> Гаргасан
- УАБЗ-ийн ССХ. (2024). “Транзит Монгол”. Аюулгүй байдал, стратеги тойм, 30(11), 8.
- ҮСХ. (2025 оны 12). <https://www.1212.mn/mn/>: [https://www.1212.mn/mn/statcate/table-view/Economy,%20environment/Foreign%20Trade/DT\\_NSQ\\_1400\\_006V3.рх-ээс](https://www.1212.mn/mn/statcate/table-view/Economy,%20environment/Foreign%20Trade/DT_NSQ_1400_006V3.рх-ээс) Гаргасан
- ЭЗХЯ. (2026). Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнүүдийн товч танилцуулга, үр дүн, явцын талаарх мэдээлэл. Улаанбаатар.

## Implementation results and issues for to be considered of the Mongolia-Russia-China Economic corridor program

Jargalsaikhan Yondonsuren

Doctor (Ph.D), Senior Research fellow, [jargalsaikhan@iss.gov.mn](mailto:jargalsaikhan@iss.gov.mn)  
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

### Abstract

*There is a growing need to expand trilateral cooperation among Mongolia, Russia, and China in order to increase trade turnover, enhance the competitiveness of goods, facilitate cross-border transportation, and advance infrastructure development. In this context, the heads of state of the three countries approved the “Program for the Establishment of the Mongolia-Russia-China Economic Corridor” during their regular meeting in 2016, which outlined 32 projects for implementation.*

*However, the slow pace of construction and implementation in recent years has limited any substantial increase in trade flows transiting through Mongolia. In particular, none of the projects intended to establish a railway transport corridor have been realized. This shortcoming can be attributed not only to constraints in capital and financing, but also to issues related to governmental instability, as well as weaknesses in project management and organizational coordination.*

*This article examines the key challenges and obstacles hindering the implementation of the Mongolia-Russia-China Economic Corridor Program and identifies the priority areas that Mongolia must address to ensure the effective realization of the planned projects.*

**Keywords:** Belt and Road, infrastructure, cooperation, trade relations, railway, road transport

## Хавсралт

## Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих төслүүдийн шинэчилсэн жагсаалт, хэрэгжилтийн явцын үнэлгээ

д/д	Төслүүд	Хариуцах яам	Хэрэгжилт (хувь)
<b>Харилцан холбогдсон дэд бүтэц</b>			
1	Төмөр замын Төв коридор (Улаан-Үд – Наушки – Сүхбаатар – Улаанбаатар – Замын-Үүд – Эрээн – Улаанцав – Жанчхүү – Бээжин – Тяньжин)-ыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах боломжийг судлах	ЗТЯ, ЭЗХЯ	30
2	“Далайн эрэг-2” олон улсын тээврийн коридор (Чойбалсан – Сүмбэр – Рашаан – Улаанхот – Чанчунь – Яньзи – Хуньцунь – Зарубино)-ыг өргөжүүлэх төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	ЗТЯ, ЭЗХЯ	0
3	“Далайн эрэг-1” олон улсын тээврийн коридор (Чойбалсан – Сүмбэр – Рашаан – Манжуур – Цицихар – Харбин – Муданьзян – Суйфэньхө – Владивосток – Находка)-ыг өргөжүүлэх төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	ЗТЯ, ЭЗХЯ	0
4	Гурван талын төмөр замын логистикийн компани байгуулах боломжийг судлах	ЗТЯ, ЭЗХЯ	0
5	Азийн автозамын сүлжээний АН-3 (Улаан-Үд – Хиагт/Алтанбулаг – Дархан-Уул – Улаанбаатар – Сайншанд – Замын-Үүд/Эрээн – Бээжингийн гаднах тойрог – Тяньжин) чиглэлийг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах, тус чиглэлд хурдны автозам барих боломжийг судлах	ЗТЯ, ЭЗХЯ	50
6	Азийн автозамын сүлжээний АН-4 (Новосибирск – Барнаул – Горно-Алтайск – Ташанта/Улаан байшинг – Ховд – Ярантай/Такашикэн – Өрөмч – Каши – Хонкираф) чиглэлийг бүтээн байгуулж, дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах	ЗТЯ, ЭЗХЯ	70
7	Автозамын Зүүн коридор (Борзя – Соловьевск – Эрэнцав – Чойбалсан – Баруун Урт – Бичигт – Зүүнхатавч – Баруун Үзэмчин – Улаанхад/Шилийн хот-Чаоян/Чэндэ – Паньжин/Жинжоу/Тяньжин чиглэл)-ийг бүтээн байгуулах боломжийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	ЗТЯ, ЭЗХЯ	0
8	Харилцаа холбооны дэд бүтцийг байгуулах ажлыг илүү идэвхжүүлж, Улаан-Үд– Хиагт/Алтанбулаг – Дархан – Улаанбаатар – Сайншанд – Замын-Үүд/Эрээн – Хөх хот Улаанцав – Бээжин чиглэлийн дамжин өнгөрөх тээврийн коридоруудын технологийн үйл ажиллагааг удирдах, аюулгүй байдлыг хангах талбарыг байгуулах	ЗТЯ, ЭЗХЯ	30

9	Улаан-Үд – Наушки – Сүхбаатар – Сайншанд – Зүүнбаян – Ханги –Мандал – Бугат – Ордос – ШиАн чиглэлд Ханги-Мандал боомтыг төмөр замаар холбох боломжийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	ЗТЯ, ЭЗХЯ	50
10	Холбогдох гол төмөр зам, автозамын боомт болон хил дамнасан голын гүүр зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтыг судалж, урагшлуулах	ЗТЯ, ЭЗХЯ	30
11	Борзя(ОХУ)–Соловьёвск–Эрэнцав(Монгол Улс)–Чойбалсан – Хөөт – Бичигт (БНХАУ) – Шилийн-Гол (Зүүнхатавч) – Улаанхад – Чаоян – Жинжоу/Паньжин чиглэлийн Зүүн төмөр замын коридор байгуулах боломжийг судлах	ЗТЯ, ЭЗХЯ	30
<b>Аж үйлдвэрийн салбар дахь хамтын ажиллагаа</b>			
12	Монгол-Орос, Монгол-Хятад, Орос-Хятадын хил дээрх чөлөөт бүсүүдийн эдийн засаг, хамтын ажиллагааны дэглэмийг уялдуулан зохицуулах боломжийг судлах	Шадар сайд	70
<b>Эрчим хүчний хамтын ажиллагаа</b>			
13	Монгол, Оросын цахилгаан эрчим хүчний сүлжээг шинэчлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүд оролцох боломжийг судлах	ЭХЯ, ЭЗХЯ	0
<b>Худалдааг дэмжих</b>			
14	2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн Монгол, Орос, Хятадын хилийн боомтын хөгжлийн салбарт хамтран ажиллах тухай Ерөнхий хэлэлцээр болон Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын гаалийн албад байгуулсан Гурван улсын хоорондын худалдааны хөгжлийг дэмжих таатай нөхцөл бүрдүүлэх талаар хамтран ажиллах тухай Санамж бичгийг хэрэгжүүлэх	СЯ, ЭЗХЯ, БСҮХ, ГЕГ	30
15	Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, ОХУ-ын Холбооны гаалийн алба, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын 2016 оны зургаадугаар сарын 23-ны өдрийн “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хоёр талын төслүүдийг боловсронгуй болгох, тухайлбал: цахим мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах, цаашид нэгтгэх	СЯ, ГЕГ	50
16	“Бүс ба зам” санаачилгын хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын салбар дахь хамтын ажиллагааны тухай Монгол, Орос, Хятадын 2015 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн Хамтарсан мэдэгдлийг хэрэгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний хил дамнасан худалдааны хяналтын хамтын ажиллагааг бэхжүүлж, худалдааны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	ХХААХҮЯ, СЯ, ЭЗХЯ, ГЕГ	30

17	Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, ОХУ-ын Холбооны мал эмнэлэг, ургамлын эрүүл ахуйн хяналтын алба, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хооронд экспорт, импортын үйл ажиллагааны явцад мал эмнэлгийн хяналт, ургамлын хорио цээр, хортон шавж болон амьтан, ургамлын онц аюултай өвчний хил дамнасан тархалтаас урьдчилан сэргийлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурахад дэмжлэг үзүүлэх	ХХААХҮЯ, СЯ, БОУАӨЯ, ГЕГ, МЭЕГ	30
18	Монгол-Хятадын, Хятад-Оросын нүүрс, халдвараас сэргийлэх, хүнс, эрүүл ахуй, хятад (монгол) уламжлалт эм зэрэг салбарын стандартыг харьцуулах ажлыг түргэтгэх	СХЗГ, ХХААХҮЯ, АҮЭБЯ, ЭМЯ, АМИТГ	50
19	Талуудын хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, баримт бичгийн мэдээлэл солилцон хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, холбогдох яам хоорондын хоёр талт санамж бичиг байгуулах талаар судлах	ХХААХҮЯ	30
<b>Ногоон хөгжил</b>			
20	Ажил хэрэгч хамтын ажиллагааг түргэтгэж, харилцаа холбоог бэхжүүлэн, зөвлөлдөж, Монгол, Хятад, Оросын “Дагуурын” дархан цаазат газрын харилцан ашигтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх	БОУАӨЯ	50
21	Монгол-Орос-Хятадын хил дамнасан хүрээлэн буй орчны коридор байгуулах, зэрлэг ургамал болон амьтны аймаг / нүүдлийн шувуу/, ус, намгархаг газартай холбогдох эрдэм шинжилгээний судалгаа болон хяналт шинжилгээ хийж, зэрлэг ан амьтан, ургамал хамгаалах салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх	БОУАӨЯ	50
22	Ногоон нүүрстөрөгч багатай үйлдвэрлэл, нүүрстөрөгчийн зах зээлийг хөгжүүлэх, ногоон санхүүжилтийн чиглэлээр шилдэг туршлага, шилдэг практикийг солилцож, ногоон, нүүрстөрөгч багатай төсөл хамтран хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	ЭЗХЯ, БОУАӨЯ	30
<b>Шинжлэх ухаан, техник, боловсролын салбарын хамтын ажиллагаа</b>			

23	Гурван улсын шинжлэх ухаан, технологийн парк, инновацын талбар хоорондын, мөн түүнчлэн тээвэр, хүрээлэн буй орчныг хамгаалах болон байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалт, амьдрахуйн шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологи, нанотехнологи ба материал, эрчим хүч, эрчим хүчийг хэмнэх ба хог хаягдлыг бууруулах, хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, аж үйлдвэрийн шинэ технологи, байгалийн болон технологийн гаралтай гамшиг зэрэг салбарт эрдэм шинжилгээний болон боловсролын байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх	ЭЗХЯ, БЯ, ЦХИХХЯ, ЗТЯ, ЭХЯ, БОУАӨЯ, ХХААХҮЯ	50
24	Талуудын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тухай мэдээллийн солилцоог урагшлуулж, эрдэм шинжилгээний ажилтнуудыг солилцох, дадлагажуулахад дэмжлэг үзүүлэх	ЭЗХЯ, ЦХИХХЯ	30
25	Оюутнуудын харилцан солилцоо болон оюутнуудыг гадаадад харилцан суралцуулах хүрээг өргөжүүлж, залуучуудын боловсролын солилцоог урагшлуулах	БЯ, ГХЯ, ССАЖЯ	30
26	Монгол-Орос-Хятадын оюуны өмчийн салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх	ЭЗХЯ, ОӨГ	50
<b>Ач холбогдол бүхий бусад төсөл</b>			
27	Монгол-Орос-Хятадын олон улсын аялал жуулчлалын “Цайны их зам” брэндийг бий болгох	ССАЖЯ	70
28	Монгол-Орос-Хятадын судалгааны байгууллагын олон улсын форум зохион байгуулах	ЭЗХЯ	30
29	Монгол-Хятад, Хятад-Оросын олон улсын найрамдалт хотын харилцааг бий болгох, найрамдалт хотын харилцаа холбоо, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх	Шадар сайд, ГХЯ	30
30	Монгол, Орос, Хятадын хэвлэл мэдээллийн салбарт хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх	МСНЭ	0
<b>Хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагаа</b>			
31	Монгол Улсын Мал эмнэлэг, үржлийн газар, БНХАУ-ын Мал эмнэлгийн газар, ОХУ-ын Холбооны мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн хяналтын алба хоорондын 2015 оны есдүгээр сарын 12-ны өдрийн Хамтран ажиллах эрмэлзлэлийн тухай Протоколыг хэрэгжүүлэх	ХХААХҮЯ, МЭЕГ	50
<b>Эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагаа</b>			

32	Анагаах ухаан болон эрүүл мэндийг хамгаалах олон улсын семинар хамтран зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах салбарт хамтран ажиллах	ЭМЯ	70
33	Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, ОХУ-ын Холбооны хэрэглэгчийн эрхийг хамгаалах, сайн сайхны төлөөх хяналтын алба болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын Нутаг дэвсгэрийн ариун цэврийн хамгаалалтын чиглэлээр хамтран ажиллах тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар халдварт өвчний хил дамнасан тархалтаас урьдчилан сэргийлэх, нутаг дэвсгэрийн ариун цэврийн хамгаалалтын чиглэлээр талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурахад дэмжлэг үзүүлэх	ЭМЯ, СЯ, ГЕГ	70